

Хэсэг 15

Монголчуудын тогтвортой амьжиргааны зарим асуудалд

Дамдинжавын Нармандах

Редакторын тайлбар: Монголчууд байгаль, бэлчээрийн мал аж ахуйн тогтвортой байдлыг хамгаалж ирсэн түүхэн уламжлалтай хэдий ч өдгөө замбараагүй, заримдаа уул уурхайн хууль бус олборлолт, бэлчээрийн даац хэтрэлт, усны хомсдол, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөө, ган, зуд зэрэг цаг уурын тааламжгүй нөхцлөөс шалтгаалан хөрсний эвдрэл, доройтлын асуудлуудтай тулгарах боллоо. Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны хөдөлмөрийн харилцааны газрын дарга Ж.Нармандах эртнээс уламжлагдаж ирсэн байгаль орчны менежментын үнэ цэнэ, орчин үеийн хөгжил, нийгмийн өөрчлөлтийн дарамт болон нийгмийн үнэт зүйлсийн өөрчлөлт зэргийг одоогийн бодлого, тусламжийн хөтөлбөртэй холбон үнэлсэн байна.

Д.Нармандах уламжлалт үнэт зүйлс болон өнөөгийн нөхцөлд гаргаж байгаа хариу үйлдлийн хоорондох ялгаа, уялдаагүй байдлыг онцлон орон нутгийн хамтын шийдвэр гаргалтыг байгаль орчны менежмент болон хуулийн дагуух уул уурхайн нөхөн сэргээлтийн асуудалтай холбох хэрэгтэй байгааг тэмдэглэсэн байна. Тэрээр Засгийн газрын хөтөлбөрүүд хэтэрхий нийгмийн хамгааллын шууд тэтгэмж төлбөр, эсвэл түүнтэй адил төстэй зүйлд найдсан байгаа нь нийгмийн болон байгаль орчны хариуцлагын уламжлалт үнэ цэнийг алдагдуулж байна гэж үзжээ. Энэ нь цаашиад эртнээс Монголчуудын дунд уламжлагдан ирсэн нийгэм, байгаль орчин, соёлын үнэт зүйлсийг хайрлан хамгаалж, дэмжин хөгжүүлэх бус, харин богино хугацааны материализмыг дэлгэрүүлдэг ядуурал, өр, эдийн засгийн хамаарлыг нэмэгдүүлэхэд хүргэж байна хэмээн дүгнэсэн байна.

Энэхүү илтгэлд Монголчуудын тогтвортой амьжиргаа хангах уламжлал, хандлага, байгаль орчны хүчин зүйлийн нөлөөллийг залуурдах төр, хувийн хэвшил, иргэдийн хандлага, чадварт гарч буй өөрчлөлтийг судлах зорилго тавьсан. Үүнд тухайлбал:

- Монголчуудын байгаль орчин хамгаалах уламжлал, хандлагын тойм гаргах;
- Өнөөгийн монголчуудын амьжиргааны үнэт зүйлүүдийн талаар тойм гаргах;
- Монголчуудын амьжиргаанд байгаль орчны хүчин зүйлүүд илүүтэй нөлөөлөх болсон нөхцөлд төр, хувийн хэвшил, иргэдийн хандлага, үйл ажиллагаанд гарч буй өөрчлөлтийг судлах зэрэг асуудлуудыг тавьсан болно.

Нэг. Монголчуудын байгаль орчин хамгаалах уламжлал, хандлага

Нүүдэлчин монголчууд эдийн засаг, нийгэм, байгаль орчин гэсэн гурван тулгуурт амьжиргааны хэв маягтай байжээ. Ийм ч учраас монголчууд байгаль орчиндоо дасан зохицож, хайрлан хамгаалж амьдрах арвин баялаг өв уламжлал, үнэт сайхан зан үйл хуримтлуулсан ард түмний тоонд зүй ёсоор ордог билээ. Монголчуудын эдгээр өв уламжлал, зан үйлийг доктор, профессор О. Амархүү энэрэл хүндэтгэлийн, хорио цээрлэлийн, сургаал номлолын, сүсэг бишрэлийн, ажиглалт танин мэдэхүйн гэсэн өөр хоорондоо харилцан нягт холбоотой 5 үндсэн ангилалд хуваасан байдаг.

Байгаль хамгаалах зан заншлын уламжлал бол нүүдэлчдийн оюун ухаан, дадал заншил, ёс суртахууны үнэт бүтээл юм.

Нүүдэлчдийн ёс заншил нь шашны зан үйлтэй холилдож ирсэн энэ уламжлал 1930-аад оны үед шашин, шүтлэгийг хязгаарласантай холбоотойгоор тасарч, үндсэндээ байгаль хамгаалах уламжлалт зан заншил үгүй болсон гэж судлаачид дүгнэжээ.

1992 онд баталсан шинэ Үндсэн хуульд зааснаар байгаль орчин хамгаалах нь иргэний журамт үүргийн нэг мөн боловч хүн бүрт байгаль хамгаалах уламжлалт заншил, зан үйл сэргээгүй байна. Байгаль хамгаалах зан заншлыг хот суурин газар, уул уурхай эрчимтэй хөгжиж буй орон нутагт хэрхэн, ямар арга, хэлбэрээр сэргээж, уламжилж үлдэх вэ гэдэг асуудал тавигдаж байна. Гэтэл өнөөдөр "Маргаашийн өөхнөөс өнөөдрийн уушиг" гэх хандлага хүчтэй түрэх болов.

Хоёр. Өнөөгийн монголчуудын амьжиргааны үнэт зүйлүүд

Монголчуудын амьжиргааны уламжлалт үнэт зүйлүүдэд үр хүүхэд, хайр, итгэлцэл, гэр бүл, эцэг эх, байгаль орчин тэргүүлэх байр эзэлдэг байв. Орчин үед урт удаан, эрүүл амьдрах, боловсрол эзэмших, нэр хүндтэй байх, амьжиргааны боломжит түвшинд амьдрах нь олон монголчуудын амьжиргааны чухал үнэт зүйлүүд боллоо. Гэхдээ Монгол Улсын хүн амын тодорхой хэсэг бүлгийн үнэт зүйл, амьдралын зорилго хэрэгжихгүй байгаа, мөн зарим хэсэг бүлэг нь үүний тулд нийгэмд хүлээн зөвшөөрөгдөөгүй арга хэрэглэдэг болсноор нийгэмд гажуудал үүссэн.

Авилгах, хууран мэхлэх, завших, хулгай дээрэм хийх, айлган сүрдүүлэх гэх мэт хууль бус арга хэрэгсэл ашигладаг хэсэг бүлэг, бодит байдлаас зугатагч орон гэргүй хүмүүс, тэнүүлчид, архичид, түүнчлэн амьжиргааны чухал үнэт зүйлүүд, зорилго болон түүнд хүрэх нийгмээс сайшаасан арга хэрэгслийг үгүйсгэгч-хувьсгалчид, үндэсний бүлгүүд, бослого хөдөлгөөн зохион байгуулагчид хүртэл бий болсон. Монголчуудыг шургуу хөдөлмөрлөх эрмэлзэлгүй болгож, эд хөрөнгөтэй болох, амжилтад хүрэх гэх мэт амьдралын зорилго, үнэт зүйлгүй болгож буй нийгмийн халамжийн хэт өгөөмөр, өрөөсгөл бодлогын улмаас эсрэгээр нийгмээсээ гээгдсэн, хүнийссэн, ирээдүйн төлөө тэмүүлэлгүй, урсгалаараа

амьдрагчид олширч байна. 2010 оны байдлаар улсын хэмжээнд хүн амын 39,2 хувь нь ядууд тооцогдож байгаа бол Улаанбаатар хотод энэ үзүүлэлт 29,8 хувь байна.

Гэнэт баяжих, хөлс хүчээ зарахгүйгээр мөнгөжих, амар хялбар амьдрах хандлага нийгмийн давхарга бүрнээ илэрч байна. Хүмүүсийн амьдралын зорилго болох үнэт зүйлсийн тоонд мөнгө, сууц, автомашин зэрэг материаллаг зүйлс саяхныг болтол голлож дараа нь ажил мэргэжил, хайр сэтгэл зэрэг нийгэм соёлын хэрэгцээ орж байв.

Философи, Социологи, Эрхзүйн Хүрээлэн, Улаанбаатар Дээд Сургуулиас 2009 онд хийсэн "Монголын гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал" суурь судалгаанаас үзэхэд "...санхүүгийн хувьд хараат бус, бие даасан байдал, материаллаг хэрэгцээ, мөнгө, амьдрах орчин нөхцөл зэрэг хүчин зүйлс аз жаргалтай байхад илүү чухал үүрэгтэй хэмээн 31,5% нь хариулсан нь өмнөх судалгаанаас 19,5 хувиар өссөн аж. Судалгаанд оролцогч гэр бүлийн эрхэмлэлийн 51,2 хувийг уламжлалт үнэт зүйлс, 48,8 хувийг орчин үеийн үнэт зүйл эзлэж байна. Хөдөөгийнхөн, гэрлэсэн, хамтран амьдрагчтай хүмүүс уламжлалт үнэт зүйлийг илүүтэй эрхэмлэж байгаа бол хотын иргэд, гэрлээгүй, салсан, бэлбэсэн хүмүүсийн хувьд орчин үеийн үнэт зүйлсийн эрхэмлэл нь давамгайл байна.

Доктор, профессор Т. Намжил "Амьжиргааны дорой байдлаас үүдэлтэй гэр бүлийн уламжлалт харилцаанд санхүүгээс үүдэлтэй сэдлийн шинэ хэв маяг бий болж байгаа нь цаашид ахмад үеэ эс хүндэтгэх, мөнгө санхүүгийн эх үүсвэр гэсэн байр суурьнаас хандах сөрөг үр дагаврыг бий болгож болзошгүй юм" гэсэн дүгнэлттэй санал нэг байна.

Гурав. Монголчуудын амьжиргаанд байгаль орчны хүчин зүйлүүд илүүтэй нөлөөлөх болсон нөхцөлд төр, хувийн хэвшил, иргэдийн хандлага, үйл ажиллагаанд гарч буй өөрчлөлт

Монгол Улс нийгэмшил, улс төр, эдийн засаг, соёл зэрэг нийгмийн амьдралын бүх хүрээг хамарсан өөрчлөлт, шинэчлэл хийж эхэлсэн 1990 оноос эхлэн тогтвортой хөгжих арга замаа өөрийн өвөрмөц соёлын үнэт өвд тулгуурлан боловсруулж, хэрэгжүүлж байна. Манай улс 1992 онд баталсан шинэ Үндсэн хуулиндаа хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулж, иргэн бүр байгаль орчин хамгаалах журамт үүрэгтэйг зааж, 1996 онд Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд тогтвортой хөгжих үзэл санааг тусгаж, 1990-ээд оны дунд үеэс ядууралтай тэмцэх хөтөлбөрийг, 1998 оноос тогтвортой хөгжлийн үндэсний хөтөлбөрийг, 2008 оноос “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ыг боловсруулан хэрэгжүүлж байгаа билээ. Тогтвортой амьжиргааны үнэт зүйлүүдэд нөлөөлдөг бодлого, институци, үйл явцыг судалж, холбогдох арга хэмжээ авч байна. Гэхдээ төрөөс ядуурал, байгаль орчин гэх зэрэг тулгамдсан асуудалд иж бүрэн хандах, салбар хоорондын зохицуулалт хийх, тогтвортой санхүүжилтээр хангахад бага анхаарч иржээ.

Хувийн хэвшилд сайн засаглал, ялангуяа байгаль орчны сайн засаглал тогтоогүй байна. 1990 оноос хойш явагдсан олборлолтын уршгаар манай орны нийт газар нутгийн 15 мянга гаруй га газар эвдрэлд орсныг БОАЖЯ-наас тогтоожээ. Нөхөн сэргээлт хийгдсэн талбайн хэмжээ дөнгөж 4 мянган га байв. Нөхөн сэргээлтийг хэрхэн хийсэн талаарх шалгалтад 200 гаруй аж ахуйн нэгж хамрагдсанаас 15 хувь нь хангалттай, 47,7 хувь нь ямар ч хангалтгүй нөхөн сэргээлт хийсэн, үлдсэн 32 хувь нь дунд зэргийн нөхөн сэргээлт хийсэн гэсэн дүн авчээ.

Монгол орны байгалийн бэлчээр нийт нутаг дэвсгэрийн

80-аад хувийг эзэлж, 32 орчим сая малыг адгуулан малладаг 160 мянган малчин өрхийн амь амьдралыг тэтгэж байна. Бэлчээрийн газрын 70 гаруй хувь нь ямар нэг хэмжээгээр доройтжээ. "... Уур амьсгалын өөрчлөлт бэлчээрийг доройтуулах гол хүчин зүйл байсан гэж үзэх үндэслэлтэй юм. Гэхдээ бэлчээрийг дур зоргоор ашиглах нь бас бэлчээрийг доройтуулах үндсэн хүчин зүйл мөн" гэж Швейцарийн Хөгжлийн Агентлаг, Монголын Бэлчээрийн Менежментийн Холбооноос хийсэн "Монголын малчдын амьжиргааны судалгаа"-нд дурдсан байна.

Бэлчээрийн газрын төлөв байдал ийнхүү доройтож байхад малын тоо толгой ган, зудын нөлөөллөөр ихээхэн хэлбэлзэх болов. Зудын нөлөөг зөөллөхийн тулд Монгол Улсын Засгийн газраас аюулаас хамгаалах тэжээлийн фонд байгуулах, цаг агаарын урьдчилсан сэргийлэх мэдээ өгөх, малыг даатгалд хамруулах зэрэг арга хэмжээ авдаг боловч энэ нь эрсдлийг олигтой бууруулж чадахгүй байна.

Монгол Улсын Засгийн газар, Швейцарийн Хөгжлийн агентлаг "Ногоон алт" Бэлчээрийн экосистемийн удирдлага хөтөлбөрийг 2004 оноос санаачлан хэрэгжүүлж байна. "Ногоон алт" хөтөлбөр эхний үе шатандаа 1) дэвшилтэт технологийг туршиж, малчдын хүртээл болгох, 2) бэлчээрийн хамтын менежментийн зарчмыг хөдөөд нэвтрүүлж, хамтран оролцогсдын хүртээл болгох 3) бэлчээр сайжруулах, бэлчээрийн хамтын менежментийг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчинг бүрдүүлэн туршиж харуулах гэсэн гурван үндсэн зорилт дэвшүүлэн ажиллажээ. Ингэснээр бага зэрэг доройтсон бэлчээрийн ашиглалтыг сайжруулахад (жишээ нь өнжөөж амрах, улирлын сэлгээ хийх зэрэг) амархан сэргэж байхад хүчтэй доройтсон бэлчээрийг уур амьсгалын өнөөгийн нөхцөлд эргүүлж сэргээхэд тун хэцүү, зардал өндөртэй болохыг Хөтөлбөрийн эхний үе шатны үр дүн илтгэн харуулжээ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад бэлчээрийн менежмент хийх нутаг дэвсгэрийн зарчмыг боловсруулж,

сумдын нутаг дэвсгэрийн хүрээнд бүх малчид Бэлчээр ашиглагчдын хэсэгт (БАХ), тэдгээр нь Бэлчээр ашиглагчдын хэсгийн холбоо (БАХХ) -нд нэгдэн зохион байгуулалтын шинэ хэлбэрт шилжсэн байна. Тухайн газар нутгийн байгалийн нөөцийг ашиглах нийтлэг ашиг сонирхолд тулгуурлаж, тодорхой хил заагийн дотор байгуулагдсан БАХ-үүд, түүнчлэн сумын түвшинд БАХ-ийг нэгтгэсэн холбоод нь Монгол оронд бэлчээрийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд хамгийн чухал алхам болох нь харагджээ. Энэ зарчмыг Бэлчээрийн тухай хуулийн төсөлд тусгаж өгчээ.

Өнөөгийн монголчуудын амьжиргааны үнэт зүйлүүдийн дотор нутаг нуга, төрөл садны харилцаанд тулгуурлах, үр хүүхдийнхээ хөгжилд анхаарах явдал уламжлал ёсоор гол байр суурь эзэлсэн хэвээр байна. Боловсрол, мэдлэгээ дээшлүүлэх, эрүүл орчинд ажиллаж амьдрах, хоол хүнсний аюулгүй байдлыг хангах, бизнес, ажил хөдөлмөр эрхэлж хуримтлал үүсгэх, мөнгөн орлого олоход орчин үеийн монголчууд ихээхэн анхаарах болжээ. Өр, зээл, мөнгөн шилжүүлэг, тэтгэлэг, тэтгэмж өрхийн орлого, зарлагын нэлээд хувийг эзлэх болов. Иргэд эвлэлдэн нэгдэж нутгийн бүлэг, нөхөрлөл, ТББ байгуулах замаар хөгжилд хувь нэмэр оруулах, шийдвэр гаргахад оролцох оролцооны механизмыг хөгжүүлж байна. Байгаль орчин, ялангуяа газар, ус, ан амьтан хамгаалах, төрөл бүрийн бохирдолттой тэмцэхэд иргэдийн санаачилга, оролцоо чухал үүрэг гүйцэтгэх болов.

Дэлхийн болоод бүс нутгийн хэмжээнд гарч байгаа уур амьсгалын өөрчлөлт, улам бүр ойрхон давтагдах болсон байгалийн гамшиг нь байгаль орчны эмзэг байдлыг нэмэгдүүлж байгаа нөхцөлд уул уурхай, байгалийн баялагт түшиглэсэн буюу байгаль орчинд халтай байж болох эдийн засгийн өсөлтийн замыг Монгол Улс сонгож аваад байна. Монголын төрийн байгууллагууд уул уурхайгаас олсон орлогыг эдийн засгаа төрөлжүүлэн хөгжүүлэх, хүнээ хөгжүүлэх, бүх

монголчуудын амьжиргааны чанарыг сайжруулахад зарцуулж ирээдүйн үеийнхний хэрэгцээнд хор хохирол учруулахгүй байх стратеги баримталж байна. Гэхдээ Хүний хөгжлийн индекс 0, 622 (Энэ үзүүлэлтээрээ манай улс дэлхийн 169 орноос 100 дугаар байрт) байгаа, институци, засаглалын үр өгөөж хангалтгүй, шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангах бодит эрх мэдэл олгоогүй, хувийн хэвшлийн нийгмийн хариуцлага хөгжөөгүй байгаа тул Монгол Улс “баялагийн хараал”-д өртөх эрсдэлтэй хэвээр байна.

Монгол Улс “Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн талаарх Үндэсний хөтөлбөр”, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицохтой холбоотой бусад хөтөлбөр, төсөл боловсруулсан. Харин хамгийн гол асуудал бол дээрх олон төслийг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэх, тэдгээрийг хэрэгжүүлэхэд хувийн хэвшил, иргэний нийгэм болон хувь хүмүүсийн үр нөлөөтэй үүрэг, оролцоог хангах механизм, арга замыг олж тогтоох явдал болж байна.

Дүгнэлт

Монгол орны уур амьсгалын өөрчлөлт, уул уурхайд түшиглэсэн эдийн засгийн өсөлт, нийгмийн халамж, хамгааллын хэт популист бодлого, үйл ажиллагаа нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эдийн засгаа оновчтой зохицуулах, ядуурал бууруулах стратегийн зорилтуудыг илүү нягт уялдуулахыг шаардаж байна.

Дэлхийн түвшинд сэтгэдэг монгол хүнийг бэлтгэх нь чухал боловч нутгийнхаа түвшинд үйл ажиллагаа явуулж амьдрах чадвартай монгол хүнийг төлөвшүүлэх явдал түүнээс бүр чухал юм. Товчоор илэрхийлбэл “Дэлхийн хэмжээнд сэтгэж, даяаршил ба уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож нутгийнхаа түвшинд үйл ажиллагаа явуулдаг, эвлэлдэн нэгдсэн монголчууд байж чадах уу” гэдэг сорилт тулгарч байна. “Баялагийн хараал” хүрсэн, тэжээн тэтгүүлдэг, эв нэгдэлгүй

улс байх уу, ирээдүй хойч үеийнхний хэрэгцээгээ хангах нөөц боломжийг алдагдуулалгүйгээр өнөө үеийн хэрэгцээг хангах эдийн засаг, нийгэм, соёл, улстөр, экологийн харилцан уялдаа бүхий цогц хөгжилтэй улс болох уу гэсэн салаа замын уулзвар дээр монголчууд ирээд байна.

Төрөөс гаргаж буй аливаа шийдвэрийн эдийн засаг, нийгэм, экологийн харилцан уялдаанд нийгмийн зүгээс тавих хяналт, оролцоо нэмэгдэж байгаа нь сайн хэрэг. Гэхдээ хүмүүс, өрхийн хэмжээнд гаргаж буй шийдвэрийн эдийн засаг, нийгэм, экологийн харилцан уялдааг бас хангадаг байх шаардлагатай. Энэ талаас нь авч үзвэл экологийн төлбөр, нөхөн төлбөрийн үндсэн дээр байгаль орчинд сөрөг нөлөө бүхий үйлдвэрлэл, үйлчилгээнд хязгаарлалт тавих эрх зүйн үндэс бий болгож, бэхжүүлэхэд цаг алдаж байна. Газрын хэвлийн болон амьтан, ургамал зэрэг баялагийг ашиглахдаа байгаль орчныг нь доройтуулж, нутгийн иргэдийн өнөөгийн аж амьдралыг залгуулах төдий хэмжээнд ажил, орлогоор хангаж буй мөртлөө гадаадад дахин боловсруулаагүй, түүхий эд хэлбэрээр харьцангуй хямд үнээр гаргаж байгаагаар ирээдүй хойч үеийнхний хэрэгцээгээ хангах нөөц, боломжийг алдагдуулж байна.

Ядуурал-байгаль орчны асуудалд анхаарал төвлөрүүлэх нь тогтвортой амьжиргаа хангах гол стратеги болж чадаагүй байна.

Ашигласан материал:

1. О. Амархүү, “Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн түүхэн хөгжил, тогтвортой хөгжилд тэдгээрийн эзлэх байр суурийн асуудал”, Улаанбаатар, 1999.
2. О. Амархүү, “Байгаль орчныг хамгаалах Монгол зан заншил, хууль цааз” (Уламжлал, шинэчлэлийн асуудал), Улаанбаатар, 1999.
3. О. Амархүү, “Монголын орчин цагийн экологийн эрх зүй”, Улаанбаатар, 2004.

4. Швейцарийн Хөгжлийн Агентлаг, Монголын Бэлчээрийн Менежментийн Холбоо, “Монголын малчдын амьжиргааны судалгаа”, Улаанбаатар, 2010
5. Монгол Улсын Хүний хөгжлийн илтгэл, Улаанбаатар, 2011
6. Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, Статистикийн бюллетень, 2010 оны 12 дугаар сар
7. Ш.Оюунханд “Нийгмийн девиаци ба амиа хорлохуй”, Улаанбаатар, 2005
8. Философи, Социологи, Эрхзүйн Хүрээлэн, Улаанбаатар Дээд Сургууль, "Монголын гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал", Суурь судалгаа, 2009